



Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2014 оны 09 дүгээр сарын 22-ны
өдрийн 1124 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ,
МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА
ЯВУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогч (даатгуулагч)-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагыг (цаашид "Сургалтын байгууллага" гэх) сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Сургалтын байгууллагын сонгон шалгаруулах

2.1. Нийгмийн даатгалын байгууллага нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг төсвийн жил бүр зохион байгуулна.

2.2. Сонгон шалгаруулалтыг тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах ба сонгон шалгаруулах тухай зарлалыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, өдөр тутмын хэвлэл, мэдээллээр мэдээлнэ.

2.3. Сонгон шалгаруулалтад оролцох сургалтын байгууллагын материалыг зарлагдсан өдрөөс хойш ажлын 10 хоногт хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор сонгон шалгаруулна.

2.4. Сонгон шалгаруулалтад орох байгууллагууд нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна. Үүнд:

а/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах эрхтэй байх (гэрчилгээний хүчинтэй хугацаа нэг жилээс багагүй байх);

б/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах туршлага (өмнө зохин байгуулсан сургалтын талаар танилцуулга)-тай байх;

в/ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн 2-оос доошгүй сургагч багш, арга зүйчээр хангагдсан;

г/ Сургалт зохион байгуулах сургалтын нарийвчилсан төлөвлөгөөтэй байх;

д/ Сургалт зохион байгуулах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материалтай;

е/ Нийгмийн даатгалын байгууллагад шимтгэл төлөгчөөр бүртгэгдсэн, шимтгэлийн тайлан тогтмол гаргадаг, нийгмийн даатгалын байгууллагад шимтгэлийн ер төлбөргүй байх;

ж/ Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн байгууллага нь сонгон шалгаруулалтад оролцох байгууллагыг нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогч (даатгуулагч)-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааг нутаг дэвсгэртээ зохион байгуулах боломжтойг нотолсон байх зэрэг болно.

2.5. Сонгон шалгаруулалтад орохыг хүссэн сургалтын байгууллага нь сонгон шалгаруулалт зарласан хугацаанд шалгуур үзүүлэлтийн дагуу бичиг баримт бүрдүүлж, ирүүлнэ.

2.6. Сургалтын байгууллагуудыг сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж, шаардлага хангасан эсэхийг шалган “тэнцсэн”, “тэнцээгүй” гэсэн үнэлгээ өгнө.

2.7. Сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлаж, зохион байгуулах Ажлын хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга томилон ажиллуулна.

2.8. Ажлын хэсэг нь “тэнцсэн” үнэлгээ авсан сургалтын байгууллагын шалгуур үзүүлэлтүүдийг 1-4 оноогоор дүгнэж, онооны жагсаалт, сургалтын байгууллагын туршлага, ажиллах хүний нөөцийн чадавхи, өмнө явуулж байсан сургалтын үр дүн зэргийг харгалзан сонгоно.

2.9. Сонгон шалгаруулалтын дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

2.10. Сонгон шалгаруулалтад тэнцсэн байгууллагатай аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс ажил гүйцэтгэх гэрээ байгуулна. Гэрээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

Гурав. Сургалтын байгууллагын үүрэг

3.1. Сургалтын байгууллага нь сургалт зохион байгуулах сонгон шалгаруулалтад орох хүсэлт, холбогдох бичиг, баримтыг тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ.

3.2. Сургалтын байгууллага нь нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогч (даатгуулагч)-ид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг “Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлага хэм хэмжээг сахин хэрэгжүүлэх, даатгуулагч (иргэн)-ийн аюулгүй ажиллах мэдлэг, дадлага олгох арга барилд сургах, зан үйлийг төлөвшүүлэх, ажил олгогчийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулна.

3.3 Сургалтын байгууллага нь сургалтын үр дүнгийн болон санхүүжилтийн тайлангаа сургалтын арга хэмжээ дууссаны дараа ажлын 7 хоногт багтаан аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэст ирүүлнэ.

3.4. Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогч (даатгуулагч)-ид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааг зохион байгуулсан тухай ажлын нэгдсэн тайлан болон дараа жил нутаг дэвсгэртээ зохион байгуулах сургалтын саналыг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газарт ирүүлнэ.

Дөрөв. Санхүүжилт, хяналт, хариуцлага

4.1. Нийгмийн даатгалд даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажил олгогч (даатгуулагч)-ид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа явуулах ажлын зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооноос баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгасан төсвийг үндэслэн санхүүжүүлнэ.

4.2 Сургалтын явц, чанар, үр дүнд аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс хяналт тавьж ажиллана.

4.3. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмыг зөрчсөн сургалтын байгууллагатай байгуулсан гэрээг цуцалж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ба дахин сонгон шалгаруулалтад оруулахаас татгалзах эрхтэй.